

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

(Энэхүү өгүүллээс эшлэл авах бол “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн нэр, дугаарыг дурдана уу.)



Лхамсүрэнгийн ОТГОНБАЯР

Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн Бизнесийн эрх зүйн ахлах багш, (LL.M - Edinburgh),
Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн докторант

ШЕРМАНЫ ХУУЛИЙН ЭХ СУРВАЛЖ: ТҮҮХЭН ТОЙМ, ӨРСӨЛДӨӨНИЙ ЭРХ ЗҮЙГ ХӨГЖҮҮЛЭХЭД ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

- I. Удиртгал
- II. Шерманы хуулиас өмнөх өрсөлдөөн ба төрийн оролцооны тухай сэтгэлгээний эх сурвалжууд
 - a) Эх зохиол, сурвалж бичгүүдийн тойм
 - b) Хууль тогтоомж, жишгийн эрх зүйн тойм
- III. Шерманы хууль батлагдах улс төр, эдийн засгийн эх сурвалж
- IV. Хууль тогтоогчийн хүсэл зориг, Шерманы хуулийн агуулга, зорилт
- V. Дүгнэлт: “Бид юуг тусгаж авах ёстой вэ?”
Хавсралт: Шерманы хуулийн эх, түүний Монгол орчуулга

ТҮЛХҮҮР ҮГС:

Өрсөлдөөний эрх зүй, антитраст, Шерманы хууль, өрсөлдөөний эрх зүйн эх сурвалж, өрсөлдөөний эрх зүйн түүх

ТОВЧЛОЛ

Энэхүү өгүүллээр Шерманы хуулийн суурь үнэт зүйл, үзэл санаа, батлан гаргахыг нөхцөлдүүлсэн нийгэм, улс төр, эдийн засгийн хүчин зүйлсийг тухайн үеийн эх зохиолууд, хууль тогтоомж болон шүүхийн жишгүүдэд тулгуурлан судалснаа хуваалцах, түүнчлэн хуулийг хэлэлцэн баталсан үйл явц, агуулга зорилтод дүн шинжилгээ хийх зорилтуудыг тавьсан. Энэхүү сэдвийг судалснаар өрсөлдөөн ба зах зээлийн эрх зүйн зохицуулалтын мөн чанарыг бодитоор ойлгоход тус нэмэр болох түүхэн баримт сэлттэй танилцах ач холбогдолтой нь дамжиггүй. Нөгөөтээгүүр, манай улсад шинэ тутам хөгжиж буй өрсөлдөөний хууль тогтоомжийг цаашид боловсронгуй болгон хөгжүүлэхэд энэхүү түүхэн эх сурвалжаас чухам ямар сургамж авч болохыг эргэцүүлснээ уншигч та бүхэнтэй хуваалцахыг давхар зорив.

I. УДИРТГАЛ

Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг батлан мөрдүүлэх замаар хөгжиж буй зах зээлийг эрүүл, динамик байдлыг нь хадгалах, өрсөлдөх үйл явцад эрх зүйт ёс, улс үндэстний эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтлах, хэрэглэгчийн эрхийг хамгаалах явдал нь “дэлхий нийтийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага”¹-ын нэг чиглэл болж байна.

Дэлхий дахины өрсөлдөөний эрх зүйн түүхэн хөгжил, түгээмэл хандлагаас суралцахад зайлшгүй эш татагддаг эрх зүйн түүхэн нэгэн эх сурвалж нь АНУ-ын парламентаас 1890 онд баталсан (санаачилсан эзнийхээ нэрээр тодотгогдон үлдсэн) Шерманы хууль билээ.

19 дүгээр зууны сүүлийн хагаст АНУ-д банк санхүү, аж үйлдвэрийн зарим салбарт зах зээлийн төвлөрөл ихсэн, монополиуд бий болж, тэдгээр нь янз бүрийн аргаар өрсөлдөгчдөө болон зах зээлээ бүхэлд нь хяналтандаа оруулах, улмаар энэ нь улс төр, эдийн засгийн хүрэн дэх нийгмийн үнэт зүйлст аюул учруулах, заримдаа шинэ технологийн хөгжлийг ч хазаарлах хэмжээнд хүчтэй нөлөө үзүүлсэн байдаг. Энэ бүгдийн эсрэг нийгэм дэх бүлгүүдийн эсэргүүцэл идэвхэжсэн. Нийгэм, эдийн засаг, улс төрийн ийм хүнд сорилтуудтай Үндсэн хуульт ёс, нийгмийнхээ суурь үнэт зүйлсийг эвдэхгүйгээр, эрх зүйн эх тогтолцоогоо баримжаалан, “хууль ёсны арга хэрэгслээр тэмцсэн” туршлага Шерманы хуулийн түүхээс харагдана. Шерманы хууль батлагдсан үйл явдал нь зах зээлд эрүүл, шударгаар өрсөлдөх эрх чөлөөг хангах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудалд гол анхаарлаа хандуулдаг өрсөлдөөний эрх зүй хэмээх эрх зүйн өвөрмөц салбар хөгжих үндэс суурь болсон юм.

¹ Монгол Улсын Үндсэн Хуулийн 5 дугаар зүйлийн 1.

II. ШЕРМАНЫ ХУУЛИАС ӨМНӨХ ӨРСӨЛДӨӨН БА ТӨРИЙН ОРОЛЦООНЫ ТУХАЙ СЭТГЭЛГЭЭНИЙ ЭХ СУРВАЛЖУУД

А. Эх зохиол, сурвалж бичгүүдийн тойм

АНУ-д 19 дүгээр зууны хоёрдугаар хагасаас олонтаа хэлэлцэгдэх болсон “траст”, “антитраст” хэмээх үзэгдэл, түүнийг зохицуулсан 1890 оны Шерманы хууль² нь зах зээлийн өрсөлдөөнийг зохицуулах талаарх дэлхий дахинд алдартай нийтийн бодлого-эрх зүйн эх сурвалж юм. Нийгэм, түүхийн шинэ үзэгдэл, ойлголтууд нь ямагт амьдралын тодорхой ахуйгаас эх үүсвэртэй. Харин түүнд хандах нийтийн бодлогын оюун санааны хөгжлийн эх сурвалжийг нийгэмд зонхилж, жин дарж байсан үзэл бодол, онол, ном, нийтлэлүүдээр төлөөлүүлэн дүгнэж цэгнэхээс аргагүй билээ.

19 дүгээр зууны Америкийн нийгмийн улс төрийн амьдралыг хэд хэдэн бүлэгт үечлэн авч үздэг бөгөөд эдгээр түүхэн цаг хугацаа бүхэнд нийгмийн үнэт зүйлсийн системд томоохон өөрчлөлт, хувьсал гарсан байдгийг харж болно. Тухайлбал, “Улс байгуулах эрин” (Founding era) –ий эхний жар гаруй жилд холбооны улс байгуулагдах, тусгаар тогтнолоо бэхжүүлэх, газар нутгаа тэлэх, иргэний дайн, боолчлолыг халах үйл явц өрнөсөн бол, Америкийн иргэний дайны дараа “Сэргээн босголтын эрин” (Reconstruction era, 1863-1877) хэмээн нэрлэгдэх цаг үед иргэний эрхийн төлөөх улс төрийн бодлого тэмцлийн эрчимжилтийн үе үргэлжилжээ. Иргэний эрх, эмэгтэйчүүдийн улс төр, нийгэм, соёлын тэгш эрхийн асуудал энэ цаг үеийн гол сэдвүүд болж байв. Үүний дараах үеийг “Алтадсан эрчин”(Gilded age, 1870-аад оноос 1900 оныг хүртэл) гэж нэрлэх бөгөөд эдийн засгийн хөгжил эрчимжиж, аж үйлдвэрлэл сэргэн Америк дэлхийн хүчирхэг гүрэн болж эхэлсэн үе юм. Улс төрийн тогтолцоонд дөрвөн том намаас голлох хоёр намын систем уруу аажмаар шилжсэн. Үүний дараа “Прогрессив буюу популист үе” (Progressive era, and Populist movement, 1890-ээд оноос Дэлхийн I дайн)³ гэж нэрлэгдэх үед эдийн засгийн эрчимтэй өсөлтөөс бий болсон сөрөг үзэгдлүүдтэй Америкийн үндсэн хуулийн үзэл санааг зөрчихгүйгээр тэмцэх ёстой гэсэн үзэл бодол хүчтэй байсан. Тухайлбал, хөдөлмөрчдийн эрх, зах зээл дэх томоохон пүүсүүдийн хэт ноёрхол, төвлөрөл, улс төр дэх цөөн хөрөнгөтнүүдийн нөлөөллийг хязгаарлан хууль ёсыг сахиулах, хээл хахуультай тэмцэх улс төрийн бодлого эрчимжсэнээрээ онцлогтой.

Америкт нэлээд радикал (эрс шинэчлэгч) шинжтэй эхэлсэн колоничлолоос тусгаар тогтнох хөдөлгөөнүүд Баруун Европт боловсрогдсон жам ёсны эрхийн номлол дээр суурилсан байна. Тухайлбал, хүний амьд явах эрх, эрх чөлөөтэй байх, өмчтэй байх жам ёсны эрх, томоохон хотуудын оршин суугчдын бүрэн эрх, Колонийн Хартид тусгагдсан бүх Америкийн оршин суугчдын эрхийг хамгаалах асуудлууд нь нэгдүгээр “Эх газрын конгресс”-оос баталсан тунхаглалд тусгагдсан нь угтаа Т.Гоббс, Ж.Мильтон, Ж.Локк, Ш.Л.Монтескье, Ж.Ж.Руссо нарын дэвшүүлсэн жам ёсны эрхийн онол тухайн үеийн Америкийн нийгэм дэх улс төрийн сэтгэлгээ, үзэл суртал төлөвшихөд үлэмж нөлөө үзүүлсний нотолгоо.⁴

Төрийн тухай сэтгэлгээнд хүмүүсийн амьдрал, чөлөөт зах зээлд аль болох хязгаартай хутгалдах засгийн газрын тухай үзэл санаа гэдгээр баруун Европын сэтгэгчдээр түүчээлэн 19 дүгээр зууны туршид Америкт тогтвортой байсан гэж үзэж болно.⁵ Чухам энэ үзэл санааны дор А.Хамилтон, Ж.Жэй, Ж.Мэдисон нар 1787-1788 оны хооронд нууц нэрээр

² АНУ хууль тогтоох практикт хууль, тогтоолыг санаачлагчийнх нэрээр нэрлэх заншилтай тул санаачлагч Жон Шерманы нэрээр Шерманы хууль гэх болжээ.

³ John, E & Frank, W (Eds) (1997) *Events that changed America in the nineteenth century*. Westport, Conn: Greenwood Press. pp 10-200

⁴ С.Базарпүрэв, *Шинэ Үеийн Өрнөдийн Улс Төрийн Сургаалын Түүхийн Товчоо XII-XIII зуун*. (Улаанбаатар: 2008) х 74

⁵ Thomas, S. (Ed) (1991) *The Political Economy of the Sherman Act: The First One Hundred Years*. Oxford: p 4

хэвлүүлж байсан нийт 85 удаагийн цуврал нийтлэлүүд (Federalist Papers)-ээр олон нийтийг соён гэгээрүүлж байв. Төрийн эрх мэдэл хуваарилах, хараат бус шүүхтэй байх тухай асуудлыг А.Хамилтоны бичсэн төгсгөлийн 78-83 дахь нийтлэлүүд хөндөж, аливаа асуудлыг дур зоргоор бус хуулиар шийдвэрлэх, хүний эрхийг хангах, хараат бус холбооны шүүхийн тогтолцоотой байхын ач холбогдлыг өгүүлжээ.⁶

Эдийн засаг дахь хувийн хэвшлийн үйл ажиллагаанд төрөөс оролцож зохицуулахаас илүүтэйгээр санхүү, бизнесийн байгууллагуудтай харилцан ашигтай хамтын ажиллагаанд түлхүү итгэл хүлээлгэж, үйл ажиллагаа явуулахад нь тааламжтай ханддаг байсан нь АНУ-ын төрийн бодлогын нэгэн уламжлал, түүхэн онцлог шинж юм. Өнөөгийн Америкийн Нэгдсэн Улс нутаг дэвсгэрийн хувьд бүрэлдэн бэхжихэд хувийн хэвшлийн оруулсан хувь нэмрийг батлах нэгэн жишээ нь Францын колонд байсан Луизиана мужийн нутаг дэвсгэрийг⁷ Наполеоны Засгийн газраас худалдан авах хэлэлцээр (1803 он)-т санхүүгийн зуучлагчаар Лондонд төвтэй “Баринг”, Амстердамд төвтэй “Хоп энд Ко” санхүүгийн компаниуд ажилласан явдал юм. Тус газар нутгийг АНУ-ын Засгийн газар 15 сая ам. доллараар худалдан авах хэлэлцээр байгуулан түүнд зориулж АНУ-ын Засгийн газраас гаргасан өрийн бичгийг эдгээр компаниуд худалдан авч Францын талд мөнгөжүүлэн өгч энэхүү хэлэлцээрийг жил гаруйхан хугацааны дотор бодитоор хэрэгжих бололцоог бүрдүүлсэн байдаг.⁸

Ричард Хофстадлерийн дүгнэж хэлснээр 19 дүгээр зууны ихэнх он жилүүдэд Америкийн нийгэм фермерүүд, жижиг хотын амбицлаг бизнесменүүдийн хөдөлгөөнтэй, өөдрөг, аз туршигч, захирангуй ёсны эсрэг, эгалтарч (тэгш эрхийн үзэл), өрсөлдөөнт нийгэм байсан. Тус нийгэм нь аристократик, милитарист, социалист онолуудтай бусадтай харьцуулахад ихээхэн бага “нүүр тулсан” нийгэм байсан гэдэг.⁹

Эдийн засгийн сэтгэлгээний хүрээнд Америкийн төрийн зүтгэлтнүүдэд хамгийн их нөлөө үзүүлсэн хүн бол сонгодог эдийн засгийн онолыг үндэслэгч Адам Смит (1723-1790) гэж хэлж болно. А.Смит тусгаар тогтнолын тунхаглалын эцэг гэгддэг Б.Франклинтай захидлаар харилцаж, улмаар тэд 1759 оны намар Шотландад уулзаж¹⁰ тухайн үеийн авилгажсан Британийн тухай болон улс төр, эдийн засгийн дэвшилтэт тогтолцооны тухай ярилцаж байсан бол Америкийн Үндсэн хуулийн “эцгүүд” гэгддэг Самуэл Адамс, Томас Жефферсон, Жэймс Мэдисон, Александр Хамилтон, Жорж Вашингтон нар бүгд “Үндэсний баялаг” зохиолыг байнга уншиж судалж байсан нь тэдний хувийн номын сан, захидал харилцааны түүх, нийтлэлүүдээр нотлогддог.¹¹

Америкийн тусгаар тогтнолын тунхаглалтай нэгэн он (1776)-д хэвлэгдсэн “Үндэсний баялаг” бүтээл нь Америкийн тусгаар тогтнолын эхэн үе төдийгүй, 19 дүгээр зууны туршид эдийн засгийн бодлогуудад зонхилох нөлөөтэй байж, тэрчлэн хувийн өмч, хөдөлмөр ба капиталыг тайлбарлах, арилжаа наймаа, худалдааны зохицуулалт, зах зээлийн капиталист тогтолцоонд хандах олон нийтийн эерэг хандлагад ч зохих нөлөө үзүүлжээ.

А.Смит эдийн засгийн амьдрал, үзэгдлүүдийн шалтгаант холбоо, харилцаа, зүй тогтлыг тухайн үеийн Британийн болон Европын улсуудын аж байдалд үндэслэн задлан шинжилж бичсэн. Тухайлбал, хөдөлмөрийн хуваариас эхлээд мөнгө, бараа бүтээгдэхүүний үнэ цэн ба түүнд зарцуулагдсан хөдөлмөрийн үнэлэмжийн харьцаа, капитал, газрын рент, нөөц баялаг ба капиталын байршил, шилжилт, хуримтлал, хотуудын үүсэл ба хотын эдийн засаг, гадаад худалдаа, гаалийн татвар, улсын зардал, улсын орлого, улсын өр гэхчлэн өргөн

⁶ <https://www.congress.gov/resources/display/content/The+Federalist+Papers> [Last accessed April 10, 2020]

⁷ Энэхүү хэлэлцээрээр худалдан авсан Луизиана муж нь Америкийн өнөөгийн нутаг дэвсгэрийн дөрөвний нэгтэй тэнцэх хэмжээтэй.

⁸ Wayne, T. De Cesar and Susan, ‘Jefferson Buys Louisiana Territory, and the Nation Moves Westward’, Spring 2003, vol. 35, No.1: Available from: <https://www.archives.gov/publications/prologue/2003/spring/louisiana-purchase.html> [Last accessed Feb 18, 2020]

⁹ Thomas, *The Political Economy of the Sherman Act*. p 20

¹⁰ Goodwin, *Benjamin Franklin in London: The British life of America’s Founding Father*, (W&N: 2017) p 119

¹¹ Адам Смит, *Үндэсний Баялаг* (Улаанбаатар: Непко, 2018) xxi тал

хүрээтэй асуудлуудыг “Үндэсний баялаг” бүтээлдээ авч үзэн үндэсний эдийн засгийг хэрхэн үр ашигтай, зөв явах арга замын тухай тухайн үеийн дэвшилтэт загварыг номлосон юм.

А.Смит эдийн засаг дахь төрийн хэт оролцоог буруушаахдаа Европын зарим улсуудад тохиолдсон алдаа завхралаар жишээлж, Засгийн газрууд үндсэндээ гурван арга замаар өрсөлдөөнд нөлөөлж байна гэж үзсэн. *Нэгд.* зарим үйлдвэрлэлд өрсөлдөөнийг цөөн тооны оролцогчоор хязгаарласнаар, *хоёрт*, жам ёсны нөхцөлд байж болохтой харьцуулбал өрсөлдөөнийг бусад үйлдвэрлэлд хүчтэй болгох хэлбэрээр, *гуравт*, хөдөлмөр болон капитал нэг үйлдвэрлэлээс нөгөөд, нэг газраас нөгөөд чөлөөтэй шилжих явдлыг хавчсанаар илэрч байна гэж үзэж эдгээр нь ямагт муу үр дагаврыг бий болгож байгааг нотлохыг зорьсон.¹²

“Үндэсний баялаг”-т зах зээл дэх хэт төвлөрөл нь хэтдээ ямар үр дагаврыг авчрах, түүнээс үүдэх үр дагавруудыг хэрхэн гэтлэх тухай номлоогүй. Мөн хувийн хөрөнгө хэт томрох үед төрөөс зохицуулан хянаж зохицуулах ёстой эсэхийг хөндөж авч үзээгүй. Тэрчлэн өрсөлдөгч нарын гаргадаг хорлонт үйл ажиллагааны хэлбэрийг хэвтээ чиглэлийн үнийн хуйвалдаанаар жишээлэн өгүүлсэн байдаг ч үүнийг хууль гарган хориглон зохицуулах боломжгүй хэмээн өгүүлжээ.¹³ Зарим судлаачид А.Смитийн бүтээлдээ хэрэглэсэн “монополь” гэдэг ойлголтод ихэвчлэн төр (эзэн хаан)-ийн шийдвэрээр бий болгосон, түүгээр хамгаалагдсан пүүсүүдийг дүрсэлсэн гэж үздэг.¹⁴

Шерманы хуулийн 1-3 дугаар зүйлүүдэд заасан улс болон муж улс хоорондын худалдааг хязгаарлахыг хориглосон үзэл санаа 19 дүгээр зуунд хэвлэгдсэн сонгодог эдийн засгийн онолын төлөөлөгч Дэвид Рикардо (1772-1823)-ийн “Улс төрийн эдийн засгийн болон татварын зарчмууд” (1817 он) бүтээлтэй зүй ёсоор холбогдоно. Тухайн үеийн нөлөө бүхий бүтээлүүд¹⁵ түүнээс эш татаж байсныг мөн дурдах хэрэгтэй. Рикардогийн үзэл санаа Европ дахинаа нөлөөтэй байсан ба Засгийн газраас өрсөлдөөнд оролцогч аль нэг этгээдэд тухайлбал, гадаадын бүтээгдэхүүний импортыг хавчих явдлыг шүүмжилсний дараа Англид 1844 болон 1846 онуудад үр тариа, худалдааны импортын хоригуудыг цуцалсан хуулиуд Парламентаар батлагдаж байжээ.¹⁶

Д.Рикардогийн дээрх бүтээлд өрсөлдөөн нь хүмүүсийг баялаг, үр ашгийг хамгийн их байлгахын төлөө өөрийн дотоод хүсэл эрмэлзлээр хөдөлмөрлөхөд хөшүүрэг болж байдаг тухай А.Смитийн үзэл санааг зөвшөөрч, хөдөлмөрийн хуваарийн гүнзгийрэл нь улс үндэстнүүдийн хоорондын чөлөөт худалдааны жам ёсны тэнцвэрийг аяндаа бий болгодог тул хууль баталж гаднын импортлогчдыг хясан боогдуулах замаар дотоодын үйлдвэрлэлийг дэмжих нь бараа бүтээгдэхүүний хомстол, үнийн өсөлт, эрэлтийг тогтвортой хангах чадваргүй болгох зэрэг олон сөрөг үр дагавруудыг авчирна гэж тайлбарласан. Улс орнууд өрсөлдөөнд ялахын тулд өөрсдийн тогтмол зардлаа багасгах, бусдаас харьцангуй хямд өртөгтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадвартаа мэргэшиж чадвал илүү үр ашигтай үйлдвэрлэл, өрсөлдөх чадвартай экспортыг бий болгож чадахыг нотолж, үүнийгээ харьцангуй давуу талын хууль гэж нэрлэсэн.¹⁷ Өрсөлдөгч нарын хоорондын хуйвалдааны тухайд ийм зүйл нийгмийн бүх хүрээнд байдаг түр зуурын нөлөөлөл (temporary effects) гэж ерөнхийлөн үзэж, энэ талаарх сэдвийг Д.Рикардо гүнзгий хөндөөгүй тойрсон байдаг.¹⁸

Америкт шинэ тутам бий болоод байсан эдийн засгийн ухаанаар дагнасан эрдэм шинжилгээний сэтгүүлүүд 19 дүгээр зууны сүүлээр хэвлэгдэж эхлээд байв.¹⁹ Чингэсэн ч

¹² А.Смит, дурдсан бүтээл, х 141-167

¹³ Мөн тэнд, х 152

¹⁴ Richard B. McKenzie and Dwight R. Lee, *In Defense of Monopoly: How Market Power Fosters Creative Production* (2011) Chapter 1, p 7

¹⁵ Рикардогийн бүтээл Х.Жоржийн болон Ж.Б.Кларкын бүтээлд аль алинд нь олонтаа иш татагдан байдаг.

¹⁶ Скаузен, *Эдийн Засгийн Ухаан Эдүгээчлэгдсэн Замнал*, (Улаанбаатар: 2003) х 89

¹⁷ David Ricardo, *On the Principles of Political Economy and Taxation* (1817, third edition 1821) Batoche Books Kitchener 2001, pp 85-104, 217-231

¹⁸ Ibid, p 57

¹⁹ Эдийн засгийн судалгааны чиглэлээр тогтмол гардаг сэтгүүлүүд болох Харвардын их сургуулийн *Quarterly Journal of Economics* сэтгүүл 1886 оноос, Чикаго их сургуулийн *Journal of Political Economy* сэтгүүл 1892 оноос тус тус хэвлэгдэж эхэлсэн байна.

онолын судалгааны хүрээнд Америкийн үндэсний эдийн засгийн амьдралд дагнан тулгуурлаж, сонгодог эдийн засгийн онолын хариулт өгөөгүй асуудлуудыг бүтээлчээр шүүмжилж засан сайжруулах зорилготой бүтээлүүд төдийлөн гарч ирээгүй байна.²⁰ Жозеф Перскийн судалснаар 19 дүгээр зуунд эдийн засгийн онолын асуудлаар Харвардын болон Чикаго их сургуулиудын эдийн засгийн сэтгүүлд 6 болон 8 удаагийн өгүүлэл хэвлэгдсэн байна.²¹ Тэдгээрээс 19 дүгээр зуунд “амжиж бүтээл нь хэвлэгдсэн” неоклассик онолын төлөөлөгч Ж.Б.Кларкын 1899 онд хэвлүүлсэн “Баялгийн хуваарилалт: Цалин хөлс, хүү, ашгийн онол” бүтээл олон улсад нэрд гарсан юм. Тэрбээр өрсөлдөөний эдийн засгийн ач холбогдлыг нэгэн үе үгүйсгэж байсан ч дээрх бүтээлээсээ хойш үзэл санаа нь тогтсон байдаг. Өрсөлдөөний тухай түүний дэвшүүлсэн гол зарчим нь чөлөөт өрсөлдөөн өөрөө хуваарилалтын үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хөдөлмөр, капиталд төдийгүй тэдгээрийг өөр хооронд нь зохицуулагч (ээд) нарт тус бүрд нь үйлдвэрлэсэн баялгийг зөв, зохистой хуваарилах хуваарилалтын үүргийг өрсөлдөөн гүйцэтгэдэг хэмээн бичиж байв.²²

Эдийн засгийн эрчимтэй хөгжлийн болоод хямралын дайвар сөрөг тусгалууд, буруутныг хайх бухимдал, айдас Америкийн нийгэмд оршин байсан нь 1880-аад оноос хэвлэл мэдээллийн хэрэгслийн гол сэдэв болж ирсэн байдаг. Америкт төдийгүй олон улсад нэрд гарч олон нийтийн эдийн засгийн ухамсар ойлголтод үлэмж нөлөө үзүүлсэн сэтгүүлч Хэнри Жоржийн 1879 оны “Дэвшил ба ядуурал” (Progress and Poverty) ном юм.

Газрын эздээс эхлэн трастуудад чиглэсэн шүүмжлэлт хөдөлгөөнийг төлөөлөгчдийн нэг гэж хэлж болох Х.Жорж газрын эзэн монополиуд үйлдвэрлэлийн өсөлт, эдийн засагт хэрхэн сөрөг нөлөө учруулж эцэстээ ажилчдыг хохироож буйг шүүмжилж, газрын эздийн бусдад түрээслүүлж байгаа газарт татвар оногдуулах санаачилга гаргасан.²³ Х.Жорж энэ байр сууриа олон талаар нотлохыг оролдсон бөгөөд газарт тогтоосон монополийг устгаснаар өрсөлдөөний зорилгыг бүрэн хангаж, шударга хуваарилалт, аж үйлдвэрлэлийн салбарт тэгш харилцааг бий болгоно гэжээ.²⁴ Газрын түрээсийн татвар нь үйлдвэрлэлийн зардлыг бууруулах, бусад төрлийн татварыг орлох зэрэг олон сайн талтай хэмээн сурталчилж байсныг зөвхөн Америкийн төдийгүй бусад улс орнуудын удирдагчид²⁵ дэмжиж байсан жишээ байдаг ч түүний дэвшүүлсэн аль ч санаачилга хууль тогтоомжид тусгагдаагүй. Харин монополиудын эсрэг явуулсан шүүмжлэлт үзэл санаа нь 20 дугаар зууны эхэн үе хүртэл олон нийтийн улс төр, эдийн засгийн ухамсарт нөлөөтэй нэг гол чиглэл байсан.

Ж.Склар, гэмгүй капитализм гэж байдаггүй бөгөөд өрсөлдөөн өргөжих, ширүүсэх нь капиталист тогтолцооны суурийг ч ганхуулж болох талтай. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн илүүдэлтэй холбоотойгоор байж боломгүй үйлдэл, ашиг сонирхлыг бий болгох, нийгэмдээ сөрөг нөлөө үзүүлэхүйц хэмжээнд хүргэхээр гажуудлыг дагуулж болно гэжээ.²⁶

Томоохон худалдаачдын явцуу ашиг сонирхол улс төр, шийдвэр гаргалтад нөлөөлөх үед хамгийн аюултай байдалд хөтөлдөг болохыг Ж.Ж.Руссо сануулж байжээ. Улс төрийн тэгш бус байдал нь хөрөнгөтнүүд өөрийн аюулгүй байдлаа баталгаажуулахын тулд бий болгодог зүйл юм гэж үзсэн. Ийм зорилгоор хууль гаргуулах замаар тэгш бус байдал бий болгох оролдлогоор хүний жам ёсны эрх зөрчигдөж байдаг гэсэн байдаг.²⁷

²⁰ Joseph Persky, ‘The Neoclassical Advent: American Economics at the Dawn of the 20th Century’, *Journal of Economic Perspective* – vol.14, Number 1, Winter 2000 p 95

²¹ Joseph Persky, *supra note p 97*

²² Ibid.

²³ Henry, G, *Progress and Poverty* (1879) Reprint (Robert Schalkenbach Foundation, 2003) p 242

²⁴ Ibid, p 176

²⁵ Paul B. Trescott, Henry George, ‘Sun Yat-Sen and China: More than Land Policy Was Involved’, *The American Journal of Economics and Sociology*, vol. 53, No. 3 (Jul., 1994), p 363

²⁶ Buch-Hansen, *The Politics of European Competition Regulation. A Critical Political Economy Perspective*, (New York: 2011), pp 13-14

²⁷ С.Базарпүрэв, *Шинэ Үеийн Өрнөдийн Улс Төрийн Сургаалын Түүхийн Товчоо XII-XIII зуун*, х 45-48

Дүгнэж хэлбэл, 19 дүгээр зуунд Америкийн нийгэмд зонхилон судлагдаж байсан улс төрийн эдийн засгийн аль ч онол, ном бүтээлд “феодалын бус дэглэм”-д хувийн өмчийн компани өргөжин тэлэхэд хязгаарлалт тавьж болох эсэх, тэрхүү эдийн засгийн асар их хүчин чадал, зах зээлд төвлөрлийг бий болгогчид аж үйлдвэрийн салбаруудыг бүхэлд нь хянах, цаашлаад улс төрд хяналтаа тогтоох замаар энэ санаархлаа гүйцэлдүүлж, өрсөлдөх, худалдаа арилжааны хүрээн дэх гэрээний чөлөөт байдлыг хавчин хүний жам ёсны эрхийг зөрчихөөс хэрхэн сэргийлэх тухайд бэлэн зэхсэн хариулт байсангүй.

Б. Хууль тогтоомж, шүүхийн жишгийн тойм

Эрх зүйн тогтолцооны хувьд АНУ нь нийтлэг эрх зүй (Common law)-н өв уламжлалыг хөгжүүлсэн нь угтаа Британийн колоничлолын үед хэрэгжиж байсан зарчмуудаас түүхэн улбаатай.²⁸ Тэгвэл Шерманы хуулийг батлагдахаас өмнө өрсөлдөөнийг зохицуулсан жишгийн эрх зүйн ямарваа нэг уламжлал, эрх зүйн сэтгэлгээний эх сурвалж байсан эсэхийг нягталж үзэх хэрэгтэй болно.

Английн эрх зүй дэх монополийн зохицуулалт нь шинэ технологи зохион бүтээгчийг дэмжих зорилготой патентын эрх зүйгээс эхлэлтэй. 16 дугаар зуунд Английн Эзэн хаанд дээрх зорилгоор бусдад патент олгох онцгой эрхийг хуульчлан олгосон. Патентын онцгой эрх бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд монополь давуу эрх олгохын сацуу патент эзэмшигч нь Эзэн хааны сан хөмрөгт татвар төлөх үүргийг хүлээлгэдэг онцлогтой байв. Харамсалтай нь хуулийн анхны утга санааг Эзэн хаад урвуулан ашиглаж, патентыг шинэ технологид бус ердийн бараа бүтээгдэхүүн (давс, цардуул болон бусад)-ий үйлдвэрлэгч, борлуулагчид зах зээлд дангаар нийлүүлэлт хийх онцгой давуу (монополь) эрх олгож эхэлсэн байна.

Энэхүү феодалын монопольт тогтолцоо нь хожим олон талын эсэргүүцэлтэй тулгарч, шүүхээр шийдвэрлэгдсэн зарим хэрэг маргаанд Эзэн хааны олгосон монополийг хуульд нийцэхгүй хэмээн шийдвэрлэж эхэлсэн байдаг. Британийн Парламентаас баталсан 1624 оны шинэчлэгдсэн хуулиар жинхэнэ патентаас бусад бүх төрлийн үйлдвэрлэл, худалдаа, борлуулалт, гэрээ, хэрэглээнд тогтоосон монополиуд хүчингүй болжээ.²⁹

Жишгийн эрх зүйн түүхэнд монополийг болон худалдааг хязгаарлахтай холбоотой эрх зүйн доктринуудыг бий болгосон “эргэлтийн цэг” гэж үзэж болох Английн шүүхийн хоёр шийдвэр (Darcy vs Allein болон Mitchel vs Reynolds) байдаг ажээ.³⁰

/а/ Английн Хатан хаанаас олгосон Англид хөзөр импортлох, худалдах онцгой эрх эзэмшигч Лорд Эдвард Дарсийн нэхэмжлэлтэй, хариуцагч худалдаа, тээврийн компанийн эзэмшигч Томас Аллинд холбогдох тус маргаан нь 1602 онд шүүхээр шийдвэрлэгджээ. Энэхүү хэргийг Английн шүүх шийдвэрлэхдээ хөзрийн худалдаанд тогтоосон монополь эрх нь тухайн этгээд барааны үнийг дур мэдэн нэмэх, худалдаа арилжаа эрхлэх сэдлийг хясан боогдуулах сөрөг үр дагавартай учир нийтлэг эрх зүйд харш гэж үзэн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгон онцгой эрхийг цуцалсан байдаг.³¹

/б/ 1711 онд Английн шүүхээр шийдвэрлэгдсэн удаах хэргийн тухайд Лондон хотын бүрэлдэхүүнд багтдаг байсан St Andrews Holborn хэмээх дүүрэгт талх нарийн боовны үйлдвэрлэл, худалдаа эрхлэгч Рэйнолд нь ижил төрлийн үйлдвэрлэл эрхлэгч Митчелд

²⁸ Британийн колоничлолын зарчмын дагуу түүний хамаарал бүхий шинэ улс (колон) байгуулагдсан тохиолдолд Английн нийтлэг эрх зүйтэй байхыг 1722 оны Английн эзэн хааны зөвлөлөөс чиглэмж болгож байжээ. *The American Law Register (1852-1891)* vol. 30, No. 9, New Series Volume 21 (Sep., 1882), p 553

²⁹ <https://www.britannica.com/topic/Statute-of-Monopolies> [Last accessed August 08, 2020]

³⁰ Harold Evans, *The Supreme Court and the Sherman Anti-Trust Act*, University of Pennsylvania Law Review and American Law Register, V 59 (1910) 2, pp 62-65

³¹ Ibid.

өөрийн ажлын байрыг 5 жилийн хугацаатай түрээслүүлсэн бөгөөд энэ хугацаанд тухайн сууринд түрээслэгчтэй өрсөлдөх ижил төрлийн үйл ажиллагаа явуулахгүй гэсэн тодорхой үнийн дүн бүхий баталгаа гаргасан. Гэвч Рэйнолд энэ хугацаандаа тухайн дүүрэгт өрсөлдөх үйл ажиллагаа эрхэлсэн тул Митчел шүүхэд нэхэмжлэл гарган баталгаагаар хүлээсэн үүргийг хангуулахыг хүссэн. Шүүх Рэйнолдын талд шийдвэр гаргахдаа тодорхой газар нутагт өрсөлдөхгүй байх үүрэг хүлээсэн хэлцэл нь түрээсийн гэрээний зорилгод хамаарахгүй учир худалдаа/өрсөлдөөн/-г үндэслэл/бодит шалтгаан/-гүйгээр хязгаарлах үүрэг хүлээсэн нь нийтлэг эрх зүйд нийцэхгүй гэж үзэж шийдвэрлэжээ.³²

Энэхүү *Mitchel vs Reynolds* шүүхийн жишгийг хожим “учир шалтгаанд захирагдах ёс” (rule of reason)-ны зарчим хэмээх өрсөлдөөний эрх зүйн уян хатан, үндэслэлтэй хэрэгжүүлэх гол үзэл баримтлалыг бий болгосон жишиг гэж үзэх болж, АНУ-ын Шерманы хуулийг хэрэглэж шүүхээр шийдэгдсэн дуулиант хэргүүд (*Standard Oil Company of New Jersey vs US*, мөн *Business Electronics vs Sharp Electronics*)-ийг шийдвэрлэхэд жишгийн анхдагч үндэс (ratio decidendi) болгон түүнээс олонтаа эш татагдсан байдаг.

Ш. ШЕРМАНЫ ХУУЛЬ БАТЛАГДАХ УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ЭХ СУРВАЛЖ

Өмнөх хэсэгт Шерманы хууль батлагдахаас өмнөх үеийн өрсөлдөөн ба эдийн засаг дахь төрийн оролцооны тухай улс төр, эрх зүй, эдийн засгийн сэтгэлгээний эх сурвалжуудад дүн шинжилгээ хийсэн бол энэ хэсэгт зах зээлийн өрсөлдөөнийг төрөөс зохицуулах эрх зүйн бодлого улс төр, эдийн засгийн хүрээнд хэрхэн бий болсон тухай түүхчлэн авч үзэж, дүн шинжилгээ хийхийг зорив.

Р.Хофстадтер өрсөлдөөн гэдэг ойлголт нь аль ч нийгмээс илүү Америкчуудын хувьд амьдралын хэвшил, итгэл үнэмшил нь байсан бөгөөд өрсөлдөөн нь нийгмийг өөрийг нь зохицуулагч эдийн засаг, улс төрийн болон ёс суртахууны өвөрмөц хэрэгсэл болж байв. Тэрбээр Америкийн өрсөлдөөний зохицуулалт нь популист хөдөлгөөнөөс эх үүсвэрлэж, нийтлэг эрх зүй (common law)-н тогтолцоон дахь худалдааны хязгаарлалтын уламжлалт тааруухан аргыг зарим хэмжээгээр авч, сонгодог эдийн засгийн онолыг оюун санааны эхээ болгож, Америкийн ардчиллын үзэл санаанд суурилан босож ирсэн юм гэжээ.³³

Ж. Стиклер Шерманы хуулийн эх сурвалжийг эдийн засагчийн рационал хандлагаар тайлбарласан. Тэрбээр энэ хууль нь популист хөдөлгөөний үр дүн гэдгийг мөн зөвшөөрч монополиудын эсрэг фермер, газар тариалан эрхлэгчдийн үйлдэл эдийн засгийн хувьд рационал байгаагүй, учир нь төмөр замын өргөжин тэлэлт гэхэд фермер, газар тариалан эрхлэгчдийн зардлыг бууруулах, орлогыг тогтмолжуулахад тус нэмэртэй байсан гэж үзсэн. Мөн өгөөж өндөртэй болон дундаж бизнесийн хувьд Шерманы хууль батлагдвал хохирохооргүй байсан бол жижиг пүүсүүдэд илүү ашигтай тусахаар байсан. Тиймээс энэ сегмент хуулийг илүүтэй дэмжиж, харин томоохон пүүсүүд эсэргүүцэж байсан гэжээ.³⁴

АНУ-д 19 дүгээр зууны сүүлийн хагаст өөр хоорондоо шалтгаант холбоо бүхий нийгэм – эдийн засгийн хүрээнд үйл явдлууд өрнөснөөр Шерманы хуулийг батлан гаргах явцыг нөхцөлдүүлсэн гэж үзэж болох бөгөөд тэдгээр нөлөөлсөн хүчин зүйлсэд (1) зах зээлийн хэт тэлэлтийн дараа эрэлт огцом унах үед өрсөлдөөн ширүүссэн нөхцөл байдал, (2) томоохон компаниудын хуйвалдаан, зах зээлд хяналтаа тогтоосон байдал, (3) үйлдвэрчний

³² Chris Dent, *Restrain Me Not: Mitchel v Reynolds and Early 18th Century Patent Law*, 41 U.W. Austl. L. Rev. 3 (2016-2017) p 8 https://www.law.uwa.edu.au/data/assets/pdf_file/0010/2986615/2-Dent.pdf [Last accessed August 18, 2020]

³³ Thomas, *The Political Economy of the Sherman Act*. p 20

³⁴ Ibid.

эвлэл, хөдөлгөөнүүдийн идэвхжил, (4) улс төр дэх трастуудын нөлөөг эсэргүүцсэн популист болон прогрессив хөдөлгөөнүүд идэвхэжсэн байдлыг тус тус хамааруулан авч үзэж болох талтай.

Нэгдүгээрт. Энэ хугацаанд АНУ-ын төмөр замын дэд бүтэц эрчимтэй өргөжсөнөөр таваарын эргэлтийг дэмжиж, харилцаа холбооны шинэ технологийн нээлтүүд нь үйлдвэрлэлийн бүтээмж болоод хүртээмж, бизнес хоорондын харилцааг хөнгөвчилж зах зээлийн их тэлэлтийг араасаа дагуулжээ. Эдгээр нь үйлдвэрлэл, борлуулалтын зардлыг хэмнэх, илүү олныг бага зардлаар үйлдвэрлэх инсентив болж өгчээ. Ингэснээр тус улсын зах зээл огцом тэлж, эдийн засгийн өсөлт урьд байгаагүйгээрээ нэмэгдэв.³⁵

АНУ-ын эдийн засаг 19 дүгээр зууны сүүлийн хагас түүхэнд үнийн бага бөгөөд тогтворгүй байдлаараа тэмдэглэгдэн үлджээ. Энэ нь макро эдийн засагт нөлөөлсөн удаа дараагийн эдийн засгийн хямралууд (1873-1878 болон 1883-1886)-аас хамаарсан эрэлтийн бууралт, нийлүүлэлтийн илүүдлээс шалтгаалсан өрсөлдөөн ширүүссэн нөхцөл байдалтай холбоотой.

Нөгөө талаар зарим томоохон салбаруудын тогтворгүй байдал ч үүнд холбогддог байна. Дийлэнхдээ үнийн бууралт нь төмөр зам, харилцаа холбооны зардал буурч ирснээр компаниудын өрсөлдөх боломж цар хүрээ өргөжин тэлж байснаар тайлбарлагддаг.³⁶

Энэ үед усан тээвэр ч мөн тээвэрлэлтийн альтернатив гэдэг утгаараа төмөр замтай өрсөлдөх хямд өртөгтэй болж ирсэн байдаг. Энэ үеийн томоохон хөрөнгө оруулалтууд ч хямд өртөгт үндэслэж байв. Хөрөнгө оруулалтыг татаж борлуулалтаа тасралтгүй нэмэгдүүлэхийн тулд үнээ хямдруулах “үнийн дайн” хийх нь түгээмэл болж ирэв. Ийм өрсөлдөөн урт хугацаандаа хэн хэнд нь ч ашиггүй байх нь мэдээж учир яваандаа тогтвортой байдлаа хадгалахын тулд өрсөлдөгч нар үнэ, ашгаа тооцон харилцан тохиролцох, үгсэх зам руу оржээ.³⁷

Тогтвортой байдлаа үгсэн тохиролцох замаар хадгалах арга хэмжээ картелиудад ашигтай хэдий ч эдийн засгийн харилцаанд оролцогч өөр бусад бүлэгт хохиролтой байв. Ялангуяа эцсийн хэрэглэгчид, борлуулагчид болон фермерүүд, жижиг үйлдвэрлэгчдэд тулгасан өндөр үнэ тэдэнд хүндээр туслаа. Жижиг бизнесүүд том өрсөлдөгчдийнхөө эсрэг, тэдний шударга бус практик аргуудыг эсэргүүцэх байдал гаргаж эхэлжээ.³⁸

Хоёрдугаарт. Эдийн засгийн хямрал, хязгаарлагдмал эрэлтийг хангахын төлөөх ширүүн өрсөлдөөний нөхцөл байдлыг даван туулахын тулд бие даасан компани хоорондын хамтын итгэлцэл бүхий асар том “траст”-ууд институцчилэгдэн өсөж өндийх болж, тэд зарим салбарын хөрөнгө оруулалтын шийдвэрт хяналт тавих, үнийг үгсэн тогтоох, үйлдвэрлэлийн хэмжээг хязгаарлах, зах зээлийг газар зүйн хил хязгаараар нь өөр хоорондоо тохиролцон хувааж авч хяналтаа тогтоох зэрэг үйл ажиллагаа явуулах болов.

“Траст”-ыг тодорхойлбол энэ нь хэд хэдэн өмчлөгч нар удирдлагын нэгдсэн бүтцээр хамтран ажиллах боломжийг бүрдүүлсэн нэг төрлийн эрх зүйн арга хэрэгсэл (legal device) юм. Өмчлөгчид өөрсдийн ашиг сонирхлоо нэг хуулийн этгээдэд нэгтгэх ба үүнийгээ “траст” гэж нэрлэнэ. Эзэд итгэмжлэгдсэн төлөөлөгч(ид)-өө томилж хамтын ашиг сонирхлыг “траст”-д төлөөлүүлэн хувь эзэмшинэ. “Траст” нь нэг фирм дотор ч байгуулагдаж болох ба “санал өгөх тарст”-аар дамжуулан олонхийг бүрдүүлж, удирдлагын шийдвэрийг хяналтдаа авах хэлбэрээр хэрэглэгдэж ч болно. Эсрэгээрээ траст нь олон эзэд хамтрахын тулд, тус тусдаа пүүсүүд байгуулж, нэгдсэн байдлаар эсхүл картель хэлбэрээр ажиллаж байв. 1882 онд Жон Рокфеллерийн хуульч Самуэль К.Т. Додд нефть боловсруулагчдын өөр хоорондоо үгсэн ажиллах боломжийг ханган үнэ болон нийлүүлэлтийг хянах, тэрчлэн мужуудын

³⁵ Motta, M. *Competition Policy: Theory and Practice*. (New York: 2004) p 2

³⁶ Motta, *Competition Policy: Theory and Practice*. p 2

³⁷ Ibid. p 3

³⁸ Ibid.

хэмжээнд үйлчилдэг татварын болон компанийн зохицуулалтаас зайлсхийхийн тулд трастыг байгуулж өгсөн байдаг. 1880-аад он гэхэд аж үйлдвэрийн салбарын ийм нэгдлүүд трастын аргыг хэрэглэх явдал хоёр дахин нэмэгдсэний хариуд муж улсуудын хууль тогтоогчдын зүгээс бизнесийн өрсөлдөөнийг зохицуулах, пүүсүүдийн хамтын ажиллагаа, аж үйлдвэрийн салбаруудыг монополичлох бизнесийн тактикуудад анхаарал хандуулах үүднээс трастын эсрэг хуулиудыг батлан гаргаж эхэлсэн.³⁹

Ийм трастууд зарим бүхэл бүтэн салбаруудад хяналтаа тогтоогоод байв. Тухайлбал, АНУ-ын гангийн үйлдвэрлэл - худалдаа, үхрийн аж ахуй, арьс, газрын тос, элсэн чихэр, виски, тамхинд монополиудын хяналт үйлчилж байв. Гагцхүү ашгийн хэмжээг зорилгоо болгосон трастууд өргөжин томорсноор тэд жижиг өрсөлдөгч нараа зах зээлээс шахан зайлуулах, нийлүүлэгч, борлуулагч нартаа өөрсдийн хатуу нөхцөлийг тулгаж, эцэстээ хэрэглэгчийг өндөр үнээр хясах явдал гаргах болов. Орон нутгийн жижиг аж ахуй эрхлэгчид, фермерүүд болон нийгэм даяараа ядууралд орохын сацуу тэдгээр монополиудын өндөр үнэтэй тэмцэх тал дээр хүчин мөхөстөх болж том трастуудын эсрэг бослого тэмцэл гарах болжээ.⁴⁰

JP Morgan нь 1901 онд “US Steel” компанийг үүсгэн байгуулсан нь салбарынхаа 70 хувийг эзэлж байв. Тэгвэл 1870 онд “Стандарт Ойл” компанийг байгуулсан Жон Рокфеллер бүх өрсөлдөгчөө замаасаа зайлуулж тээвэр, газрын тос, жижиглэн худалдаанд монополичлох тогтоож газрын тосон бүтээгдэхүүний зах зээлийн 88 хувийг эзэмшиж, зах зээлийг нь бүрэн хянаж байв.⁴¹

Гуравдугаарт. Томоохон корпорацуудын эзэд өөрсдийн хөрөнгийн хэмжээгээрээ өрсөлдөж эхлэхэд ашгийг хамгийн их байлгахыг туйлын зорилгоо болгосон үйлдвэрүүд цалингийн зардлаа багасгаж, ажлын цагаа нэмэх болсон нь ажилчдад хүндээр тусах болжээ. 19 дүгээр зууны сүүлийн арваад жил нь АНУ-ын түүхнээ хамгийн олон үйлдвэрчний эвлэл, хөдөлгөөний бослого, үймээнтэй жилүүд болж тэмдэглэгдэн үлджээ. Олон улсын хөдөлмөрийн байгууллагад бүртгэлээр 1850-1899 онуудын хооронд нийтдээ 60 удаа хөдөлмөрчдийн бослого хөдөлгөөн⁴² гарсны 55 нь АНУ-д гарсан байдаг.⁴³

Дөрөвдүгээрт. АНУ-ын олон ургалч улс төрийн систем хэдийн иймэрхүү тогтолцооны эсрэг босч чадах нийгмийн өргөн хүрээг хамарсан сегментээс бүрдсэн байлаа. Ийнхүү тэд Популист нам байгуулсан нь хожим Прогрессив нэртэй хөдөлгөөн болж өргөжжээ. Эдгээр хөдөлгөөнүүд 1873-1874 онд баруун төв хэсгийн 11 мужийн хууль тогтоох байгууллагад нөлөө үзүүлж ялалт байгуулсан юм. Шерманы хууль батлагдахаас өмнө эдгээр хөдөлгөөнүүдээс тус монополиудыг хязгаарласан хуулийг батлахыг шаардсан агуулгатай 59 өргөх бичиг Конгресст ирсэн байжээ.

Хувийн компанийн өргөжин томроход хэмжээ тогтоох эсэх, төрийн оролцоогүйгээр тодорхой зах зээлд зохион байгуулалт хийх эрхийн хэмжээ хязгаар, тэр нь “дүрмээрээ тоглож буй” дундчуудыг хавчих болсныг эрхбиш хязгаарлах тухай асуудал нь олон нийтээс шаардаж буй шаардлагын гол зүйл байв. Энэ үед сенатын гишүүн Жон Шерман (1823-1900) том трастийг хязгаарласан хууль санаачилсан нь 1890 онд АНУ-ын Конгрессоор батлагдаж энэ нь хожим Шерманы хууль хэмээн алдаршсан билээ.⁴⁴

³⁹ Laura Phillips Sawyer, ‘US Antitrust Law and Policy in Historical Perspective’, Harvard Business School Working Paper Number: HBS Working Paper #19-110 (May, 2019) p 2, Available from: <https://hbswk.hbs.edu/item/us-antitrust-law-and-policy-in-historical-perspective> [Last accessed on February 25, 2020]

⁴⁰ Buch-Hansen, *The Politics of European Competition Regulation*. p 28

⁴¹ Ажэмолу болон Робинсон, *Улс Үндэстний Уналт Доройлтын Шалтгаан*, (Улаанбаатар: 2016) х 272

⁴² <http://laborsta.ilo.org/applv8/data/c9e.html> [Last accessed on February 02, 2020]

⁴³ Baird, *Labour Law Reform: Lessons from History*, (Cato Institute: 1990) p 6 <http://object.cato.org/sites/cato.org/files/serials/files/cato-journal/1990/5/cj10n1-10.pdf> [Last accessed on Feb 25, 2020]

⁴⁴ Buch-Hansen, *The Politics of European Competition Regulation*. p 28

IV. ХУУЛЬ ТОГТООГЧИЙН ХҮСЭЛ ЗОРИГ БА ШЕРМАНЫ ХУУЛИЙН АГУУЛГА, ЗОРИЛТ

Өмнөх хэсэгт Шерманы хуулийг батлагдах гол шалтгаан болсон улс төр, эдийн засгийн үйл явдлуудад дүн шинжилгээ хийсэн бол харин энэ хэсэгт тус хуулийг батлах үед хууль тогтоогчийн хүсэл зориг хэрхэн тодорхойлогдож байсан хийгээд ямар зорилтууд тавигдаж байсныг авч үзнэ.

Дэвид Миллоны тодорхойлсноор Шерманы хуулийг хэлэлцэх үед Конгресс хоёр том сорилттой нүүр тулсан байдаг нь **нэгдүгээрт**, нийгэмд хэт өргөн хүрээг хамраад байсан трастуудын эсрэг чиглэх шүүмжлэл, тэмцэл, **хоёрдугаарт**, хүчний тэнцвэрийг тогтоохыг шаардсан олон нийтийн тулган шаардалт гэжээ.⁴⁵

Харин Р.Хофстадлер, АНУ-ын Конгрессын баталсан Шерманы хууль нь эхнээсээ гурван үндсэн зорилт агуулсан гэж үзсэн. **Нэн тэргүүнд эдийн засгийн зорилт.**⁴⁶ Сонгодог өрсөлдөөний загвар ёсоор бол өрсөлдөөн нь эдийн засгийн үр ашгийг хамгийн их байлгадаг. Энэ ёсоор үгүй ядаж Конгрессын тодорхой хэсэг нь энэ үзэл санааных нь төлөө дэмжсэн болов уу. **Хоёрдугаарт, улс төрийн зорилт.** Өрсөлдөөний зохицуулалт нь хувийн хэвшлийн нөлөө бүхий бүлэглэлээс ардчилсан засаглалаа хамгаалахад үйлчилж байх ёстой гэдэг үзэл санаанд тулгуурлана. **Эцэст нь, нийгэм – ёс суртахууны зорилт.** Өрсөлдөх процесс нь нэг төрлийн хөгжилд хөтлөх механизм гэсэн итгэл үнэмшилд үндэслэнэ. Өрсөлдөх чадвар бол бол үндэстний өсөн дэвжих суурь өдөөгч гэж үзэх тул энэ итгэл үнэмшлийг хамгаалах ёстой гэсэнд энэ зорилтын мөн чанар оршино.⁴⁷

Шерманы хуулийн талаар хууль тогтоогчийн илэрхийлсэн хүсэл зоригийг Роберт Ланди тодорхойлсон нь сонирхолтой бөгөөд үнэнд тун ойр юм. Түүнийхээр өрсөлдөөний зохицуулалтын анхны зорилго сэдэл төдийгүй хойшдын сорилт нь нийгмийн баялгийн шударга, үр ашигтай хуваарилалтыг бий болгоход оршино гэжээ. Тэрбээр, монополь үнийн хамгийн ойлгомжтой үр дагавар бол баялаг нь худалдан авагчаас монополь руу шилжиж, хэрэглэгч хохирч монополь хөрөнгөждөг явдал гэжээ.⁴⁸

Гэтэл эндээс өрсөлдөөн төдийгүй эдийн засагт ихээхэн нөлөө үзүүлэхүйц “улсын хэмжээний анхны” эрх зүйн баримт бичиг (Шерманы хууль) нь зөвхөн хувь ганц Конгрессын гишүүний санаачилсан зүйл байсан уу гэдэг асуулт үлдэж байна.

Ер нь нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээнд үүссэн олон нийтийн бухимдлыг аль болох мэргэжлийн түвшинд үнэн зөвөөр задлан шинжилж, цаг алдалгүй хариу үйлдэл хийж шийдвэрлэхгүй орхивол бухимдал даамжирч нигилизм, эсхүл хэт радикал хөдөлгөөнд хүргэж болзошгүй байдаг нь ажиглагддаг. Хуулийн хэлэлцүүлэг дээр хууль санаачлагч Ж.Шерман хэлэхдээ “улам бүр хүчээ аван томорч буй монополиудын эсрэг арга хэмжээ одоохон авахгүй бол олон түмний санаа бодол нийгмийн зохион байгуулалтаа эвдэхүйц хэмжээний бужигнаантай байна. Конгресс үүнд анхаарал хандуулах ёстой. Эс бөгөөс коммунизм, социализм, нигилизмтэй нүүр тулахад бэлдэх хэрэгтэй” хэмээн анхааруулж байв.⁴⁹

⁴⁵ Thomas, *The Political Economy of the Sherman Act*. p 20

⁴⁶ Ричард Хофстадлер эдийн засгийн зорилтын хувьд нөгөө хоёроосоо хамаагүй бүрхэг байсан гэж үздэг бөгөөд өрсөлдөөний зохицуулалтаар концепцын хувьд тодотгох чухал аргумент байхгүй байсан ажээ. Энэ хуулийг хэлэлцэх үед тухайн чиглэлийн эксперт байхгүй байсан тул хууль тогтоогч зөвлөгөө авах боломжгүй байжээ. Хуулиас дөнгөж өмнөхөн нь Америкийн эдийн засгийн нийгэмлэг байгуулагдсан боловч түүнийг сонгодог эдийн засгийн эсрэг үзэлтэй эрхэм байгуулсан учир зөвлөгөө авлаа ч хоёр талтай зүйл хэлэх байсан гэж таамагласан байдаг. Ibid. p 24

⁴⁷ Ibid. 23-24

⁴⁸ Ibid. p 20; pp. 73-74

⁴⁹ Ibid. p 22

1890 онд Шерманы хуулийг баталсан нь Конгресс зүгээр л олон нийтийн хүлээлтэд хариу өгч амыг нь хаах гэсэн ёгтлол байсан эсэх талаар мэтгэлцээн өрнөдөг. Хөрөнгө чинээтэй давхаргаас бүрдсэн Сенатын танхим ийм хардлага дагуулах нь аргагүй юм. Хуулийн төслийг хэлэлцэж байх үед сенатч Орвил Платт “үнэн хэрэгтээ ирээдүйд улс орон дагаж мөрдөж явахаар тийм хууль батлахаар бэлтгэж байгаа юм шиг ойлголт төрөхгүй байна. Зүгээр л ямар нэгэн хууль гаргаж, тэр нь трастуудыг шийтгэх боломж олгосон мэт ойлголт өгөх гэж байгаа байдал ажиглагдлаа” гэсэн үл итгэсэн үг хэлсэн нь тэмдэглэгдэн үлджээ.⁵⁰

Трастуудын эсрэг мужийн хэмжээнд үйлчлэх хуулиудыг 1880 оноос эхлэн өмнөд мужууд бүгд, цаашлаад АНУ даяар нийтдээ 42 муж улсууд баталчихсан байжээ. Мөн энэ хуулийг батлах үеийн санал хураалтад Конгрессын 242 гишүүд бүгд дэмжсэн санал, Сенатын 53 гишүүнээс зөвхөн нэг нь татгалзах санал өгсөн байдаг нь Шерманы хуулийн төслөөр дэвшигдэж буй асуудал зөвхөн хувь гишүүний гэнэтийн санаачилга санамсаргүйгээр дэмжигдсэн гэх үгүйсгэлийг үнэмшилгүй болгож байна.

Чухам шинэ хууль тухайн үед ямар чиглэл, шинэ ойлголт, феномен бий болгосон бэ гэдэг дээр судлаач Роберт Боркийн байр суурь эргэлзээгүй хариулт болно гэж үзэж байна. Роберт Борк нь Шерманы хуулийг хууль тогтоох засаглалаар хэлэлцсэн процессыг судлан Шерманы хуулийг хэрэгжүүлэгчдэд удирдамж болохуйц бодлогын ямар зарчмын заалтууд орсныг тодорхойлжээ. Юуны өмнө Боркийн бичсэнээс Шерманы акт нь олон Сенатчийн идэвхтэй оролцоо, тэдний (Эдмундс, Реган, Ингалс, Жорж нар) альтернатив төслүүдэд үндэслэн, Конгрессын санхүүгийн, шүүхийн хороодоор дамжин хэлэлцэгдэн дахин найруулагдсан ч Шерманы анхлан санаачилсан үзэл санааг агуулж батлагдсан болох нь харагддаг. Хуулийн үзэл санаанд хэрэглэгчийг хамгаалах асуудал хамгийн том зарчим болж орсон бөгөөд түүнээс өөр ямар ч шалгуурыг шүүхийн зүгээс гаргаж тавихыг хууль тогтоогч эс зөвшөөрсөн юм.⁵¹

Ийнхүү Шерманы хуулийн агуулга, зорилт, түүнийг АНУ-ын конгресс хэлэлцэгдэн баталсан процесс, хууль тогтоогчийн хүсэл зориг, ялгаатай байр сууриудыг тус тус шинжлэн авч үзсэнээр хууль тогтоогч нь нийгэм дэх сонирхлын бүлгүүдийн шахалт шаардлагад ёс суртахууны хэм хэмжээнд нийцүүлэн хариу өгсөн. Чингэхдээ хууль батлан гаргах замаар хариу өгснөөрөө нийгмийн өмнө ирсэн сорилтод үндсэн хуулийн үнэт зүйлсээ өөрчлөхгүйгээр, хууль ёсны арга хэрэгслийн тусламжтайгаар хариу арга хэмжээ авснаараа түүхэн ач холбогдолтой байсан гэж дүгнэж болох юм.

Энэхүү өгүүлэлд Шерманы хуулийн 1890 оны уг эхийг Монгол хэлнээ орчуулж хавсаргасан бөгөөд анхны эх дээрх ойлголт, зарчмууд нь цаашид баяжиж эх нэр томъёогоор олон улс орнуудад хэрэглэгдэж байна. Шерманы хууль хэрэгжиж эхэлснээр аж үйлдвэрийн олон салбарын трастуудад холбогдох хэргүүдийг шалгаж эхэлсэн. Тухайлбал, элсэн чихэр, газрыг тос, тамхины гэх аж үйлдвэрлэлийн олон салбарууд үүнд дурдагдана.

АНУ-ын өрсөлдөөнийг зохицуулсан хууль тогтоомжууд	Агуулга	НҮБ-ын нийтэлсэн Өрсөлдөөний загвар хуулийн ⁵² агуулгад туссан эсэх
Шерманы хууль(1890)-аар зохицуулагдсан харилцаа	Худалдаа, өрсөлдөөнийг хязгаарласан үйл ажиллагаа, хэлцлүүд:	Загвар хуулийн 1 дүгээр бүлгийн агуулга
	• Үнийг үгсэх	Тийм
	• Зах зээлийг газарзүйн хувьд хуваах	Тийм

⁵⁰ Ibid.

⁵¹ Ibid. pp 39 - 46

⁵² https://unctad.org/en/Docs/tdrbpconf7d8_en.pdf [Last accessed: August 26, 2020]

	<ul style="list-style-type: none"> Иж бүрдэлд ороогүй нөхцөл тулгах 	Тийм
	<ul style="list-style-type: none"> Ялгавартай нөхцөл тавих 	Тийм
	<ul style="list-style-type: none"> Монопольчлох 	Тийм
	<ul style="list-style-type: none"> Өрсөлдөөний хууль тогтоомжийг сахиулах байгууллагын эрх зүйн байдал 	Тийм
	<ul style="list-style-type: none"> Өрсөлдөөний эрх зүйн зөрчилд хүлээлгэх хариуцлага 	Тийм
Клейтоны хууль (1914)-аар зохицуулагдсан харилцаа	<ul style="list-style-type: none"> Өрсөлдөөнд харшлах нэгдэж, нийлэх үйл явц 	Тийм
	<ul style="list-style-type: none"> Зах зээлд ноёлох үйл ажиллагаа 	Тийм
	<ul style="list-style-type: none"> Хэрэглэгчийг ялгаварлах 	Тийм
Холбооны шударга худалдааны хууль (1914)-аар зохицуулагдсан харилцаа	<ul style="list-style-type: none"> Хэрэглэгчийг төөрөгдүүлэх үйл ажиллагаа 	Тийм
	<ul style="list-style-type: none"> Шударга бус өрсөлдөөний бусад аргууд 	Тийм

Дээрх харьцуулалтаас үзэхэд Шерманы хуулиар зохицуулагдсан харилцаа нь орчин цагийн өрсөлдөөний эрх зүйн хамгийн суурь харилцааг зохицуулсан байна. Өдгөө АНУ-д 1914 онд Клейтоны хууль, Холбооны шударга худалдааны хууль гэсэн тодотголтой хуулиуд батлагдсан нь өрсөлдөөний зохицуулалтыг цаашид улам төрөлжүүлэн нарийсгасан юм. Энэ нь Шерманы хуулиар зохицуулагдаагүй бусад харилцааг хуулиар зохицуулах, өрсөлдөөнийг эрх зүйн практик бий болсон хийдлүүдийг арилгах зорилтыг агуулсан байдаг.

V. ДҮГНЭЛТ: “БИД ЮУГ ТУСГАЖ АВАХ ЁСТОЙ ВЭ?”

Шерманы хууль батлагдсан үйл явцын мөн чанар, зорилт, онолын болон улс төр, эдийн засгийн эх сурвалжийг судалснаар олон чухал асуудлын зангилааг тайлах танин мэдэхүй, онол, практикийн хувьд ач холбогдолтой гэж дүгнэж байна.

АНУ-ын Үндсэн хуулийн үзэл санаа болох төр - эдийн засгийн амьдралын хамгийн чухал хөдөлгөгч хүч чөлөөт өрсөлдөөнд аль болох оролцохгүй байх тухай номлодог сонгодог эдийн засгийн сургаалд нэгэн сул тал байв. Энэ нь “феодалын бус дэглэм”-д өсөж томорсон хувийн компаниудын хүчирхэгжилтэнд хязгаарлалт тогтоох ёстой эсэх асуултаас эхэлсэн. Цөөн компаниудын төвлөрөл, монополиуд аж үйлдвэрийн салбаруудыг бүхэлд нь хянах, цаашлаад улс төрд хяналтаа тогтоож төрөөс ч илүү хүч, нөлөөтэй болсон нь бодит байдал болсон. Улмаар эдгээр цөөнх бусдын өмч хөрөнгө шударгаар олж авах жам ёсны эрх, тэрчлэн өрсөлдөх, гэрээний чөлөөт байдалд заналхийлэх үед ямар арга хэмжээ авах талаар бэлэн зэхсэн хариултгүй байв.

Газрын эздээс эхлэн томоохон бизнесүүд рүү чиглэсэн шүүмжлэл өргөн хүрээтэй газар авсныг бид авч үзсэн. Энэ үед гарсан радикал санаачилгууд газрын түрээс, газрын татварын реформ уруу чиглэснээс бус үүсээд байсан асуудлыг оносонгүй. Үгсэн хуйвалдах, өрсөлдөгчөө шахан зайлуулах, зах зээлд төвлөрөл үүсгэх, зах зээлийг хянах зэргийг

зохицуулахад тухайлан чиглэгдсэн бодлогын альтернативыг хараахан дэвшүүлж чадаагүй байна.

Холбооны улсын хэмжээний өрсөлдөөний хуулийг зайлшгүй батлан гаргах явцыг нөхцөлдүүлсэн хүчин зүйлс(сорилт)-д: (1) зах зээлийн хэт тэлэлтийн дараа эрэлт огцом унах үед өрсөлдөөн ширүүссэн нөхцөл байдал, (2) томоохон компаниудын хуйвалдаан, зах зээлд хяналтаа тогтоосон байдал, (3) үйлдвэрчний эвлэл, хөдөлгөөнүүдийн идэвхжил, (4) улс төр дэх трастуудын нөлөөг эсэргүүцсэн популист болон прогрессив хөдөлгөөнүүд идэвхэжсэн байдал тус тус хамаарна. Эдгээр үйл явцууд нь ердийн нэг улс төрийн хүрэн дэх хийрхэл төдий хэлбэртэй зүйл биш байсныг бид өмнө нь нотолгоотой авч үзсэн.

Хууль тогтоогч нь нийгэм дэх сонирхлын бүлгүүдийн шахалт шаардлагад ёс суртахууны хэм хэмжээнд нийцүүлэн хариу өгсөн. Чингэхдээ хууль батлан гаргаж шударга бус өрсөлдөөнд тооцох шалгуур, зарчмуудыг хуульчлан тодорхойлох замаар хариуцлагын механизмыг бий болгожээ. Ингэснээрээ нийгмийнхээ өмнө тулгараад байсан сорилтыг даван туулахдаа нийтлэг үнэт зүйлс, үндсэн хуульт ёсноос ухралт хийхгүйгээр хууль ёсны арга хэрэгсэлд тулгуурлах арга замыг сонгосон байна.

Харин өрсөлдөөнийг зохицуулсан холбооны хэмжээнд үйлчлэх анхны хууль (Шерманы хууль)-ийг боловсруулахад Английн жишгийн эрх зүйд бүрэлдэн тогтсон эдийн засгийн бодит үндэслэлгүй монополь бий болгохыг хориглох (Darcy vs Allein) жишиг, өрсөлдөөн болон худалдаа, гэрээний чөлөөт байдлыг үндэслэлгүйгээр хязгаарлахыг хориглох (Mitchel vs Reynolds) жишгийн эрх зүйн уламжлалт зарчмуудыг авсан бөгөөд энэ нь сонгодог эдийн засгийн сургаалтай зөрчилдөөгүй.

Шерманы хуулийг хэлэлцэж байх үед зарим сенатчийн зүгээс мэтгэлцээний үеэр “үнэн хэрэгтээ ирээдүйд улс орон дагаж мөрдөж явахаар тийм хууль батлахаар бэлтгэж байгаа юм шиг ойлголт төрөхгүй байна. Зүгээр л ямар нэгэн хууль гаргаж, тэр нь трастуудыг шийтгэх боломж олгосон мэт ойлголт өгөх гэж байгаа байдал ажиглагдлаа” гэсэн үл итгэсэн хандлага илэрхийлсэн байдаг. Харин Шерманы хуулийг батлагдсаны дараа трастуудтай холбоотой олон хэргүүдийг шүүх шийдвэрлэсэн нь үүнд хариулт болно. Хожмоо эдгээр хэргүүд нь өрсөлдөөнийг зохицуулах хууль зүйн арга хэрэгслийг боловсруулахад хамгийн их эш татагддаг жишгүүд болжээ. Мөн Шерманы хуулийн хүрээ нь өрсөлдөөнийг зохицуулах олон улсын загвар хуультай олон талаар давхацдаг болохыг бид авч үзсэн, магадгүй энэ загвар хуулийн анхдагч эх сурвалж нь Шерманы хууль гэж үзэхэд хол зөрөхгүй.

Шерманы хуулийн эх сурвалжууд, түүнийг батлан гаргасан үйл явцаас манай улс зөвхөн өрсөлдөөний хууль тогтоомжоо боловсруулахад дараах сургамжуудыг тусган авах боломжтой гэж үзэж байна. Үүнд:

- Өрсөлдөөний хууль тогтоомжийн шинэчлэлийг хийхдээ Үндсэн хуульт байгууллынхаа анхдагч онолын үндэс, үнэт зүйлсийнхээ суурийг сайтар судлах, судалгаа шинжилгээнд үндэслэхгүйгээр ямарваа эрс алхам, эсхүл өөр өөр онолуудыг дүйцүүлэхэд болгоомжтой хандах.
- Өрсөлдөөний хуулийн үйлчлэлд шууд хамаарах болон дам нөлөө үзүүлж буй нийгмийн бүлгүүдийн үзэл бодлуудыг нарийвчлан авч үзэж, тэдгээрийн эрх, хууль ёсны болон бодит ашиг сонирхол, чиглэлүүдийг ялгамжтай тодорхойлох.
- Гадаад улс орнуудын өрсөлдөөний хууль тогтоомжийн тэргүүн туршлагыг судлахдаа дан ганц норматив хэм хэмжээг бус, гадаадын хууль тогтоомжийн түүхэн цаг үе, нийгэм, эдийн засгийн эх сурвалж, тус хуулийн хэрэгжилтийг шүүхийн практик, түүний уламжлал шинэчлэлтэй нь харьцуулан судалж байх.

- Өрсөлдөөний салбарын хууль зүйн зохицуулалтын арга хэрэгслүүдийг хууль тогтоомжид тусгахдаа формаль логикийн хийсвэрлэлийн аргаас гадна, эдийн засгийн болон техникийн бодит учир шалтгаанд захирагдах ёс (rule of reason) -ыг харгалзан үзэх. Өөрөөр хэлбэл, эконометрикийн болон техникийн тодорхой арга зүй, шинжилгээгээр батлагдаж, эсхүл нотлогдож байж тухайн хэм хэмжээ хэрэгждэг шалгуур тогтоож өгөх нь чухал гэж үзэж байна.

ХАВСРАЛТ

ШЕРМАНЫ ХУУЛЬ (1890 ОН)⁵³

Жич: Эрх зүйн соёл, хууль зүйн техникийн ялгаанаас хамаарч Монгол орчуулгад агуулагдсан үг хэллэг та бидний уншиж дассан хууль зүйн хэл, найруулгаас ялгаатай байхыг болгооно уу.

Анхны эх бичвэр	Орчуулга
<p>Fifty-first Congress of the United States of America, At the First Session,</p> <p>Begun and held at the City of Washington on Monday, the second day of December, one thousand eight hundred and eighty-nine.</p> <p>An act to protect trade and commerce against unlawful restraints and monopolies.</p> <p><i>Be it enacted by the Senate and House of Representatives of the United States of America in Congress assembled,</i></p> <p>Sec. 1. Every contract, combination in the form of trust or otherwise, or conspiracy, in restraint of trade or commerce among the several States, or with foreign nations, is hereby declared to be illegal. Every person who shall make any such contract or engage in any such combination or conspiracy, shall be deemed guilty of a misdemeanor, and, on conviction thereof, shall be punished by fine not exceeding five thousand dollars, or by imprisonment not exceeding one year, or by both said punishments, at the discretion of the court.</p> <p>Sec. 2. Every person who shall monopolize, or attempt to monopolize, or combine or conspire with any other person or persons, to monopolize any part of the trade or commerce among the several States, or with foreign nations, shall be deemed guilty of a misdemeanor, and, on conviction thereof; shall be punished by fine not exceeding five thousand dollars, or by imprisonment not exceeding one year, or by both said punishments, in the discretion of the court.</p> <p>Sec. 3. Every contract, combination in form of trust or otherwise, or conspiracy, in restraint of trade or commerce in any Territory of the United States or of the District of Columbia, or in restraint of trade or commerce between any such Territory and another, or between any such Territory or Territories and any State or States or the District of Columbia, or with foreign nations, or between the District of Columbia and any State or States or</p>	<p>Америкийн Нэгдсэн Улсын Конгрессын Тавин Нэг дэх удаагийн хуралдааны эхний чуулган,</p> <p>Вашингтоны хотод арванхоёрдугаар сарын хоёр дахь өдөр эхэлж, зохион байгуулагдлаа, нэг мянга найман зуун наян есөн он.</p> <p>Худалдаа ба арилжааны хууль бус хязгаарлалт, монополиос хамгаалах хууль.</p> <p><i>Америкийн Нэгдсэн Улсын Сенат болон Конгресс дахь Төлөөлөгчдийн Танхимаас тогтоосугай,</i></p> <p>Зүйл.1. Тус тусын муж эсхүл гадаад улсуудыг хамарсан худалдаа, арилжааг хязгаарлах аливаа төрлийн гэрээ, траст эсхүл өөр бусад төрлийн хамсал, хуйвалдааныг хууль бус гэж тооцсугай. Хамсал, хуйвалдааны ийм гэрээ эсхүл харилцаанд оролцсон аливаа этгээдийг шүүхээс зөрчил (misdemeanor)-ийн хэрэгт гэм буруутайд тооцож, таван мянга хүртэл доллараар торгох, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл буюу дээрх хоёр хариуцлагыг хамтад нь оногдуулна.</p> <p>Зүйл.2. Монопольчилсон аливаа этгээд, монопольчлохыг завдсан этгээд, эсхүл нэг болон хэд хэдэн этгээдтэй хамсах буюу хуйвалдан тус тусын муж эсхүл гадаад улсуудыг хамарсан худалдаа, арилжааг монопольчилсон бол шүүхээс зөрчлийн хэрэгт гэм буруутайд тооцож, таван мянга хүртэл доллараар торгох, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл дээрх хоёр хариуцлагыг хамтад нь оногдуулна.</p> <p>Зүйл. 3. Нэгдсэн Улс, Колумбия дүүрэг (District of Columbia)-гийн аль нэг нутаг дэвсгэр дэх худалдаа, арилжааг хязгаарлах аливаа төрлийн гэрээ, траст болон өөр бусад төрлийн хамсал, хуйвалдаан, эсхүл эдгээр нутаг дэвсгэрийн хооронд эсхүл эдгээр нутаг дэвсгэр болон аливаа муж, мужуудын хооронд эсхүл Колумбия дүүрэг, гадаад улс, түүнчлэн Колумбия дүүрэг болон аливаа муж, мужууд, гадаад улсуудын</p>

⁵³ <https://www.justice.gov/atr/file/761131/download> [Last accessed: August 26, 2020]

foreign nations, is hereby declared illegal. Every person who shall make any such contract or engage in any such combination or conspiracy, shall be deemed guilty of a misdemeanor, and, on conviction thereof, shall be punished by fine not exceeding five thousand dollars, or by imprisonment not exceeding one year, or by both said punishments, in the discretion of the court.

Sec. 4. The several circuit courts of the United States are hereby invested with jurisdiction to prevent and restrain violations of this act; and it shall be the duty of the several district attorneys of the United States, in their respective districts, under the direction of the Attorney-General, to institute proceedings in equity to prevent and restrain such violations. Such proceedings may be by way of petition setting forth the case and praying that such violation shall be enjoined or otherwise prohibited. When the parties complained of shall have been duly notified of such petition the court shall proceed, as soon as may be, to the hearing and determination of the case; and pending such petition and before final decree, the court may at any time make such temporary restraining order or prohibition as shall be deemed just in the premises.

Sec. 5. Whenever it shall appear to the court before which any proceeding under section four of this act may be pending, that the ends of justice require that other parties should be brought before the court, the court may cause them to be summoned, whether they reside in the district in which the court is held or not; and subpoenas to that end may be served in any district by the marshal thereof.

Sec. 6. Any property owned under any contract or by any combination, or pursuant to any conspiracy (and being the subject thereof) mentioned in section one of this act, and being in the course of transportation from one State to another, or to a foreign country, shall be- forfeited to the United States, and may be seized and condemned by like proceedings as those provided by law for the forfeiture, seizure, and condemnation of property imported into the United States contrary to law.

Sec. 7. Any person who shall be injured in his business or property by any other person or corporation by reason of anything forbidden or declared to be unlawful by this act, may sue therefor in any circuit court of the United States in the district in which the defendant resides or is found, without respect to the amount in controversy, and shall recover three fold the damages by him sustained, and the costs of suit, including a reasonable attorney's fee.

Sec. 8. That the word "person," or " persons," wherever used in this act shall be deemed to include corporations and associations existing under or authorized by the laws of either the United States, the laws of any of the Territories, the laws of any State, or the laws of any foreign country.

Approved, July 2, 1890.

хоорондын худалдаа, арилжааг хязгаарлах нь хууль бус гэж тооцогдоно. Хамсал, хуйвалдааны ийм гэрээ эсхүл хэлцэл хийсэн аливаа хүнийг шүүхээс зөрчлийн хэрэгт гэм буруутайд тооцож, таван мянга хүртэл доллараар торгох, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл буюу дээрх хоёр хариуцлагыг хамтад нь оногдуулна.

Зүйл. 4. Энэ хуулийг зөрчигдөхөөс сэргийлэх, түүнийг таслан зогсоохыг Нэгдсэн Улсын тус тусын тойргийн шүүхэд хуулиар харьяалуулсан; түүнчлэн Нэгдсэн Улсын Ерөнхий Прокурор(Attorney-General)-ын удирдлага дор тус тусын дүүргийн прокурорт тус тусын харьяалсан нутаг дэвсгэртээ эдгээр зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох шударгаар хянан шийдвэрлэх ажиллагааг хариуцан явуулахыг үүрэг болгож байна. Тэдгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг гомдлоор хэрэг үүсгэх, мөн зөрчлөө өөрөө хүлээж ирснээр үүсгэх хэлбэрээр эхлүүлж болох ба бусад хэлбэрийг хориглоно. Гомдол гаргагч талууд гомдлоо зохих ёсоор гаргасан тохиолдолд, тийнхүү гаргамагц шүүхийн сонсгол дээр болон хэргийг тодорхойлох ажиллагаагаар эхлүүлнэ; түүнчлэн ажиллагаанд байгаа гомдолд болон шүүхээс эцсийн шийдвэр гарахаас өмнө хэдийд ч шүүхээс зөвхөн тодорхой нөхцөл заан түр хязгаарлалт тогтоосон шийдвэр болон түр хориглолт тогтоосон шийдвэрийг гаргаж болно.

Зүйл. 5. Энэ хуулийн дөрөвдүгээр зүйлд заасны дагуу явагдаж байгаа шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэдийд ч хэргийн нөгөө талыг шүүхийн өмнө аврах хүртэл түр зогсож, шүүхээс тэдгээрийг зарлан дуудна, хянан шийдвэрлэж байгаа дүүргийн шүүхээс өөр газар амьдардаг эсэхээс үл хамааран зарлан дуудах бичгийг аль ч дүүрэгт маршал гүйцэтгэнэ.

Зүйл. 6. Энэ хуулийн нэгдүгээр зүйлд заасан хамсал, хуйвалдаан бүхий гэрээний үндсэн дээр өмчлөгдсөн (болон түүнд хамаарч байгаа) болон нэг мужаас нөгөөд эсхүл өөр улс уруу тээвэрлэгдэж байгаа эд хөрөнгө нь Нэгдсэн Улсад нийгэмчлэгдэж, хураагдаж болох бөгөөд тэдгээрт явагдах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь Нэгдсэн Улсад хууль зөрчин импортлон ирсэн хөрөнгийг ялын дагуу хураах, нийгэмчлэх, хураахтай холбоотой хуулиудаар зохицуулагдана.

Зүйл. 7. Бизнес болон эд хөрөнгөөр, түүнчлэн аливаа этгээдээс эсхүл корпорацаас энэ хуулиар хориглосон эсхүл хууль бус гэж тооцогдсон үйлдлээс шалтгаалан хохирсон бол хариуцагчийн оршин суудаг, олдсон газрын Нэгдсэн Улс дахь аль ч дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж болно. Маргааны хэмжээнээс үл хамааран үүний улмаас учирсан хохирлыг гурав дахин нэмэгдүүлж, нэхэмжлэлийн зардлыг, үүнд өмгөөлөгчийн үндэслэл бүхий хөлсийг нөхөн олгоно.

Зүйл. 8. Энэ хуульд заасан “этгээд”, эсхүл “этгээдүүд” гэдэг үг нь энэ хуульд хэрхэн

	<p>хэрэглэгдэхээс үл хамааран Америкийн Нэгдсэн Улсын хууль тогтоомж, аливаа нэг нутаг дэвсгэрийн хууль, аливаа муж улсын хууль тогтоомж, эсвэл аль нэг гадаад улсын хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа эрхэлдэг, эсхүл тийнхүү зөвшөөрөгдөөгүй корпорацууд, холбоог хамаарна.</p> <p>Батлав, 1890 оны 7 сарын 2</p>
--	---